



ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ

2019 оны 1 сарын 15 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Монгол Улсын 2019 онд экспортлох, импортлох стратегийн хүнсний тоо, хэмжээний тухай

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 18 дугаар зүйлийн 18.5-д тус тус заасныг үндэслэн Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлөөс ЗӨВЛӨМЖ болгох нь:

Монгол Улсын 2019 онд экспортлох, импортлох стратегийн хүнсний тоо хэмжээг дор дурдсан хэмжээнд хүртэл тогтоохыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаанд зөвлөсүгэй.

Нэг. ЭКСПОРТ

- 1.1 Үхрийн мах – 29,900 тонн (хорин есөн мянга есөн зуу)
- 1.2 Адууны мах – 31,000 тонн (гучин нэгэн мянга)

Хонь, ямааны мах экспортлох тоо, хэмжээнд хязгаар тогтоохгүй байх.

Хоёр. ИМПОРТ

- 2.1 Үрийн улаанбуудай: 10,000 тонн (арван мянга)
- 2.2 Улаанбуудайн гурил 11,000 тонн (арван нэгэн мянга)
- 2.3 Меслин: 1,000 тонн (нэг мянга)
- 2.4 Үхрийн мах: 500 тонн (таван зуу)
- 2.5 Хуурай сүү: 6,000 тонн (зургаан мянга)
- 2.6 Шингэн сүү: 720 тонн (долоон зуун хорь)

Гурав. Савласан цэвэр ус импортлох, экспортлох тоо хэмжээг 2019 онд тогтоох шаардлагагүй гэж үзэв.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



У.ХҮРЭЛСҮХ